МАГАДЛАГЧ ЭМЧ, МЭРГЭЖИЛТЭН Б.АМАРЖАРГАЛЫН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| *Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.* | | | | | | | |
| 1.1 | Нийгмийн даатгалын багц хууль болон Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомж, шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | ЭММТЗ-өөс өгсөн чиглэлийн дагуу 4 судалгаа гарган хүргүүлсэн. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 01 албан даалгавар болон 2 чиглэл, Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын 1 чиглэлийн хэрэгжилтийн тайланг хугацаанд нь хүргүүлэв. Хэрэгжилтийн тайланг хавсаргав. | 2025.01.02 2025.12.10 | |
| *Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт* | | | | | | | |
| 2.1 | Ажил олгогч, даатгуулагчаас илгээсэн хүсэлтийн дагуу хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн амаржсаны эмнэлгийн хуудасны бичилт, олголтод цахимаар хяналт тавих | Хянасан тоо | ХЧТА- 3369, ҮО-ын ХЧТА 97, ЖА 1561 даатгуулагчийн хүсэлт ирсэн. | ЭМБ-аас даатгуулагчид олгосон эмнэлгийн хуудсыг шаардлагын дагуу зөв, хугацаандаа бичигдсэн, эрх | Нийгмийн даатгалын систем portal.ndaatgal.mn сайтаар хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн хүсэлт илгээсэн 1552, ҮОМШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн хүсэлт 45, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлт илгээсэн 569, нийт 2121 эмнэлгийн хуудасны | 2025.01.02 2025.12.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | үүссэн эсэхийг хянасан байна. | бичилт, олголтыг sicos.ndaatgal.mn веб програмаар хянав.<br><br>Хяналтын явцад тэтгэмж авах эрх үүсээгүй, эмнэлгийн хуудас урьчилж олгосон, эмнэлгийн байгууллага хугацаа хэтрүүлж олгосон, өвчний шалтгаан буруу, ажил олгогч мэдээллийг буруу илгээсэн, ихэр төрөлт биш, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон оношоор эмнэлгийн хуудас олгогдсон, хугацаандаа хүсэлт гаргаагүй, цэрэг цагдаагийн байгууллагын цолтой албан хаагч, гэрийн хаяг буруу зэрэг шалтгааны улмаас 203 эмнэлгийн хуудсыг буцаах арга хэмжээ авав. | | |
| 2.2 | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, холбогдох байгууллагатай хамтран хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн шилжилт хөдөлгөөн, нас баралтын мэдээллийг тулган нягтлах, шинэчлэх | Улирал тутам тулгасан байна. | 2024 онд шилжиж ирсэн 7, шилжиж явсан 18. | Мэдээллийг тухай бүр шинэчилж, үнэн зөв мэдээлэл бүрдүүлсэн байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 20 удаагийн хурлаар шийдвэрлэсэн нийт 686 иргэний мэдээллийг үнэн, зөв бүрдүүлсэн эсэхэд хяналт тавьж ажиллав.<br>Хяналтын явцад хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, сунгалтын он сар өдөр, оношийн код, гэрийн хаяг буруу 8, өвчний ангилал буруу 4 тохиолдолыг тус тус илрүүлж залруулах арга хэмжээ авлаа.<br>Түүнчлэн нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын тэтгэврийн массивыг зөвлөлийн хурлын мэдээллийн сантай | 2025.01.02<br>2025.12.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тулган шилжиж явсан 7, шилжиж ирсэн 1, нас барсан 39, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн жил буруу 9 иргэний хөдөлгөөнийг тус тус залруулав.<br><br>Хурлын үед хийгдсэн хөдөлгөөний мэдээллийг тухай бүр хянаж Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн ehmkweb програмд файл илгээж байна. | | |
| *Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт* | | | | | | | |
| 3.1 | Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт болон Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааг зохион байгуулах, дотоод хяналт тавих | Зөвлөлийн хурлын үйл ажиллагаанд оролцож, хяналт тавьж заавар, зөвлөгөө өгсөн байна. | Зөвлөлийн хуралд 47 удаа оролцсон, 51 иргэний асуудлыг түдгэлзүүлсэн | Зөвлөлийн хуралд тогтмол оролцож, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьсан байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 20 удаагийн хуралд оролцож хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтыг зөвлөлийн төрөлжсөн мэргэжлийн эмч нараар хянуулж, шинжилгээний бүрдэл дутуу, баталгаажилт хангалтгүй 23 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг түдгэлзүүлэв.<br><br>Зөвлөлийн хурлаар танилцуулга хийж буй эмчлэгч эмч нарт эпикриз бичилтийг сайжруулах талаарх зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна. | 2025.01.02<br>2025.12.10 | |
| 3.2 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, тушаал, | Төлөвлөгөө, тайлан, мэдээний тоо | Тухай бүр | Тайлан мэдээг хугацаанд нь чанартай гаргаж | Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд 2024 оны жилийн эцсийн тайлан, зөвлөлийн хурлын цагийн бүртгэлийн, маягтын | 2025.01.02<br>2025.12.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | | | тайлагнасан байна. | зарцуулалтын тайлангуудыг тус тус гаргаж хугацаанд нь хүргүүлэв.<br>Төв зөвлөлд ҮОМШӨ-ний даатгалын сангаас сувиллын болон унааны зардал авсан даатгуулагчийн судалгаа, сэтгэцийн өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн судалгаа, 2017-2024 онуудад хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн судалгаа, хөдөлмөрийн чадвар алдалтад тэргүүлж буй 5 өвчнийг назологиор нь задалсан судалгаа, эмнэлгийн хуудас олгох журамд өөрчлөлт оруулах санал, зөвлөлийн хуралд ажилласан гишүүдийн хурлын цагийн судалгаа, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвөөс ирсэн албан бичгийн дагуу НДС-аас ХЧА-ны тэтгэвэр авагч иргэдийн судалгаа, сар бүрийн мэдээ зэрэг нийт 13 мэдээ, судалгааг тус тус хугацаанд нь гарган хүргүүлж ажиллалаа. | | |
| 3.3 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, | Зөрчилгүй ажилласан байна.<br>Мэдэгдэл, тайлбар гаргасан тоо. | Тухай бүр | Хууль тогтоомж, журмыг мөрдлөг болгон ажилласан байна. | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гарган, холбогдох мэргэжилтэнд баталгааны маягтыг хүлээлгэн өгөв. | 2025.01.02<br>2025.12.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | | | | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 2024 оны жилийн эцсийн тайлан, хурлын тэмдэглэл, цагийн бүртгэл, зөвлөлийн бүртгэл болон зөвлөлийн төрөлжсөн мэргэжлийн эмч нарын гэрээний биелэлттэй холбоотой баримт бичгүүдийг архивлан нэгж үүсгэж 1 ботийг архивт хүлээлгэн өгөв.<br><br>Албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу 19 албан бичиг төлөвлөж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. | | |
| 3.4 | Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад гарсан Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хязгаарлалт тогтоосноос бусад аливаа хууль бус үйлдэл, зөрчил, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх | Аливаа хууль бус үйлдэл, зөрчил, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг мэдсэн даруйд холбогдох албан тушаалтанд мэдээлэх. | - | Холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөн ажилласан байна. | Одоогоор ямар нэгэн зөрчилгүй байна. | 2025.01.02<br>2025.12.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5 | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааны зардлын төсвийг хуульд заасан хугацаанд боловсруулж, санал өгөх | Төсвийн төсөл, төсөөллийн санал өгсөн хугацаа, үндэслэл | Хуулийн хугацаанд боловсруулж, санал өгсөн байна. | Төсвийн төсөл, төсөөллийг үндэслэлтэй боловсруулсан байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааны зардлын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсөөллийг Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл өөрсдөө боловсруулсан болно. | 2025.06.01<br>2025.06.10 | |
| *Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт* | | | | | | | |
| 4.1 | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын дунд ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгуулах | Зохион байгуулсан тоо | 2 удаа | Амбулаторийн картын болон оношийн үндэслэлийн бичилт сайжирсан байна. | Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 09/75 тоот удирдамжийн дагуу ижил мэргэжилтний үзлэгийг 2025 оны 06 дугаар сарын 13-нд Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлтэй хамтран зохион байгуулахаар төлөвлөн, бэлтгэл ажлыг хангаж байна. | 2025.06.06<br>2025.12.10 | |
| 4.2 | Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүд болон иргэдэд чиглэсэн сургалт зохион байгуулах | Сургалтад оролцогчдын тоо | 1 удаа | Авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан байна. | Тус газрын магадлагч эмч "Нүдний өвчний орчин үеийн оношилгоо, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоохоод анхаарах асуудлууд" сэдэвт сургалтад УБ хотод танхимаар хамрагдсан ба уг сургалтын хөтөлбөрийн дагуу "Авлигын гэмт хэрэг ба авлигын хор хөнөөл" сэдвээр бүлгээр ажиллаж, мэдээлэл авсан байна.<br><br>АТГ-аас зохион байгуулсан Эрүүгийн хууль, авлигын гэмт хэргийн талаарх сургалтад Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 7 гишүүн цахимаар хамрагдлаа. | 2025.01.02<br>2025.12.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3 | Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах | Сургалт, сурталчилгааны тоо | - | Сургалт, сурталчилгаа хийгдсэн байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүн дотрын мэргэжилтэн хоол боловсруулах эрхтний эмгэгээс урьдчилан сэргийлэх, элэгний өөхжилт, хатуурлын оношилгоо, эмчилгээний менежментийн талаарх богино хэмжээний мэдээллийг цахимаар тогтмол хүргэн ажиллаж байгаа ба уг мэдээллүүд нийтдээ 800 гаруй мянган иргэдэд хүрчээ.<br><br>Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга болон тэтгэмжийн байцаагчтай хамтран үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх дүрэм, нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх мэдээллийг лайваар хүргэв. Уг мэдээлэл 4000 гаруй иргэдэд хүрсэн байна. | 2025.01.02<br>2025.12.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4 | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн тайлан мэдээнд судалгаа шинжилгээ хийх | Хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа хийж, орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагад танилцуулсан байна. | Хагас жил тутам | Зөвлөлийн тоон тайланд дүн шинжилгээ хийсэн байна. | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21 иргэнээр буюу 0.56 хувиар буурсан үзүүлэлттэй байна.<br><br>Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолтыг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзэхэд жил бүр 1.33-4.47 хувиар тогтмол буурч байгаа боловч аймгийн нийт хүн амын тоонд харьцуулахад улсын дунджаас өндөр үзүүлэлттэй хэвээр байна.<br><br>Аймгийн нийт хүн амын 4.4 хувийг хөдөлмөрийн чадвар алдсан иргэд эзэлж байна.<br><br>Хөдөлмөрийн чадвар алдалтын шинэ тогтоолтын 85 орчим хувийг дотрын өвчин (37.3%), хорт хавдар (16.1%), гэмтэл согогийн өвчин (17.8%), нүдний өвчин (5.0%), мэдрэлийн өвчин (9.3%) тус тус эзэлж байна.<br><br>Нийт хөдөлмөрийн чадвар алдалтын 81.9 хувийг сэтгэц, | 2025.01.02<br>2025.12.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дотор, гэмтэл согог, нүд, чих хамар хоолойн өвчин эмгэг эзэлж байна.<br><br>Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын зонхилох шалтгаан болж буй эхний 5 өвчний ангилал болон өндөр үзүүлэлттэй байгаа сумдын судалгааг гарган АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, ЭМГ, БОЭТ, сумдын Засаг дарга нарт албан бичгээр мэдээллийг хүргүүлээд байна. | | |
| 4.5 | Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэнүүд болон иргэд даатгуулагчдад эмнэлгийн хуудас олгох журам, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох өвчний жагсаалтын талаар мэдээ, мэдээлэл хүргэх | Постер, мэдээ мэдээлэл хүргэсэн тоо | 2 удаа | ЭМБ-ын эмч нарт эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомж, эмнэлгийн хуудас бичилт, олголтын чиглэлээр мэдээ, мэдээллийг хүргэж ажилласан байна. | Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”-ын талаарх сургалтыг тус газрын магадлагч эмч 2025 оны 02 дугаар сарын 5-14-ний өдрүүдэд танхимаар болон цахимаар зохион байгуулав.<br>Сургалтад Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Уламжлалт анагаах ухааны эмнэлэг, Өрх болон сумын эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн нийт 21 эрүүл мэндийн байгууллагын 160 орчим эмч мэргэжилтнүүд хамрагдлаа.<br><br>Уг сургалтад Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Асралт үйлс, Мянган жаргалан, Ягаан цээнэ өрхийн эрүүл мэндийн төвүүд танхимаар, Уламжлалт анагаах | 2025.01.02<br>2025.12.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ухааны эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүд цахимаар тус тус оролцов. | | |
| 4.6 | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг зохион байгуулах | Зохион байгуулсан тоо | - | Төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа зохион байгуулсан байна. | Нийт албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн дэд хорооны ажиллах журмын талаар мэдээлэл өгч, Ёс зүйн дэд хорооны гишүүдийг сонгох үйл ажиллагааг зохион байгуулан албан хаагчдын саналыг авч, Газрын даргын А/10 тоот тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн томилов. Шинээр томилогдсон Ёс зүйн дэд хорооны 3 гишүүд Ёс зүйн хороо болон НДЕГ-ын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан 2 удаагийн сургалтад цахимаар хамрагдан бүлгээр ажиллаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлэв. Түүнчлэн НДЕГ-ын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулж байгаа “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ” сэдэвт сургалтад 13 сумын байцаагчид болон аймгийн төвийн 6 байцаагч нар хуваарийн дагуу хамрагдаад байна.<br><br>Ёс зүйн дэд хороо нь Чойбалсан сумын байцаагч Т.Туяацэцэгтэй холбоотой гомдол, холбогдох баримт, тайлбарыг үндэслэн Ёс зүйн дэд хорооны хурлаар | 2025.01.02<br>2025.12.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэлэлцэж, ёс зүйн зөрчилгүй гэсэн дүгнэлт гаргасан. Үүнтэй холбогдуулан Ёс зүйн дэд хорооны дарга хамт олны мэдээллийн цагаар цаашид даатгуулагч, иргэдтэй харьцахдаа зөв зохистой, үг үйлдэл, биеийн хэлэмж зэрэгтээ онцгой анхаарч ажиллахыг нийт албан хаагч нарт анхааруулав. | | |
| 4.7 | Нийгмийн даатгалын хууль, тогтоомж ач холбогдлыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад сурталчилах | Сургалт, сурталчилгаа, мэдээллийн тоо | Тухай бүр | Иргэд, ААНБ-д нийгмийн даатгалын ач холбогдлын талаар мэдээ, мэдээлэл хүргэсэн байна. | Эрүүл мэндийн магадлал, эмнэлгийн хуудасны бичилт, олголт, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны болон жирэмсэн амаржсаны тэтгэмж, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, сайн дурын даатгал, нийгмийн даатгалын гар утасны аппликейшны талаар утсаар болон биечлэн ирсэн нийт 90 гаруй даатгуулагч (иргэн)-д мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.<br><br>Түүнчлэн БОЭТ, УАУТөв, 13 сумын эрүүл мэндийн төв, 3 өрхийн эрүүл мэндийн төв, 3 хувийн хэвшлийн нийт 21 эрүүл мэндийн байгууллагын 160 гаруй эмч мэргэжилтэнд эмнэлгийн хуудас олгох журмын талаар мэдээлэл хүргэв. | 2025.01.02<br>2025.12.25 | |
| 4.8 | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх | Хамрагдсан даатгуулагчийн тоо | 11 | Өгсөн үүргийн дагуу сайн дурын даатгалд даатгуулагч | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон 130 гаруй иргэдэд сайн дурын | 2025.01.02<br>2025.12.25 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамруулсан байна. | даатгалын талаар мэдээлэл өгч, цахимаар хэрхэн гэрээ байгуулах чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөв. Ингэснээр шинээр 9 иргэн сайн дурын даатгалд хамрагдаад байна. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Газрын даргын өгсөн үүргийн дагуу ажилгүйдлийн тэтгэмж олголтын зөрүүтэй мэдээллийг ялгахад туслах | Ажилгүйдлийн тэтгэмжийн жагсаалтыг тулгаж зөрүүг олж тайлбар бичих | - | Ажилгүйдлийн тэтгэмжийн жагсаалтыг мэдээллийн сантай тулгаж зөрүү үүссэн шалтгааныг олсон байна. | 2024 оны жилийн эцсийн тайлан гаргахтай холбоотой 389 даатгуулагчид олгосон ажилгүйдлийн тэтгэмжийн жагсаалтыг мэдээллийн сан болон хувийн хэрэгтэй нэг бүрчлэн тулган, хуучин програмаас шинэ нэвтэрсэн sicos програмд хөрвөхдөө алдаатай буруу олголт үүссэн дүнд тайлбар бичив. Нийт тулгалтын 65 хувьд нь олговол зохих дүн давхардаж буруу үүссэн байв. Шалтгаан нь 2023 онд ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орж зогсоогдсон даатгуулагчийн олгогдоогүй үлдсэн дүнгээр давхардаж буруу хөрвөн үүссэн, sicos програмын хуваарь цэсд хуваарь буруу давхардаж үүссэний улмаас олговол зохих дүн илүү үүссэн алдаа ээлж байв. | 2025.01.13<br>2025.01.28 | |
| 2 | Захиргаа хяналтын хэлтсийн даргын өгсөн үүрэг даалгавар | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн боловсруулах | | Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна. | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын төслийг шинэчлэн боловсруулж, албан хаагчдад танилцуулан хэлэлцүүлж саналыг авч нэгтгэн Газрын даргаар батлуулав. | 2025.04.01<br>2025.04.21 | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Монгол бичгийн ур чадварыг сайжруулах | Сургалтад хамрагдсан тоо | - | Богино хугацааны сургалтад хамрагдсан байна. | “Монгол бичиг” пейжд нэгдэж монгол бичгийн уншлагаа сайжруулж байна. | 2025.01.02<br>2025.12.10 | |
| 2. | Сургалт болон бусад нэгдсэн арга хэмжээнд оролцож мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх | Сургалтад хамрагдсан тоо | 16 | Сургалтад хамрагдсан байна. | -Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан Эрүүгийн хууль, авлигын гэмт хэргийн талаарх сургалтад цахимаар хамрагдлаа.<br><br>-Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс зохион байгуулсан магадлагч эмч нарын “Нүдний өвчний орчин үеийн оношилгоо, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтооход анхаарах асуудлууд” сэдэвт 2 хоногийн сургалтад УБ хотод танхимаар хамрагдаж, 2 кредит цагийн батламж гардан авсан.<br><br>-Ёс зүйн хороо болон НДЕГ-ын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан 2 удаагийн сургалтад цахимаар хамрагдан бүлгээр ажиллаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлэв. | 2025.01.02<br>2025.12.10 | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Магадлагч эмч, мэргэжилтэн — Б.Амаржаргал ( ) — 2025.06.04.

*( Албан тушаал )* — *( Нэр, гарын үсэг )* — *( Огноо )*